



БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2018 оны 09 сарын 05 өдөр

Дугаар А/522

Булган

Газар албадан чөлөөлөх тухай

Газрын тухай хуулийн 57 дугаар зүйлийн 57.4 заалтыг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Булган сум 5 дугаар Анхдагчдын өргөн чөлөө 1 дүгээр гудамж 134 тоотод байршилтай “Энержи плас” /5847001/ ХХК, 5 дугаар баг Чин ван Ханддоржийн өргөн чөлөө 2 дугаар гудамж 208 тоотод байршилтай “ООБС” /3185184/ ХХК, 6 дугаар баг 6 дугаар гудамж гудамжны дунд хэсэгт айл өрхүүдийн орц гарцыг хааж зөвшөөрөлгүй буусан иргэн М.Цэрэнханд /АС81110301/ нарын нийтийн эзэмшил талбайд дур мэдэн зөвшөөрөлгүй барьсан хашаа, гэрийг албадан чөлөөлсүгэй.

2. Албадан чөлөөлөх ажлыг холбогдох хууль, журмын дагуу зохион байгуулахыг аймгийн Цагдаагийн газар хурандаа /З.Гомбо/, Булган сумын Засаг дарга /Д.Наранбаяр/ нарт тус тус даалгасугай.

3. Захирамжийн биелэлтийг 2018 оны 9 дүгээр сарын 14-ны дотор танилцуулахыг аймгийн Цагдаагийн газар хурандаа /З.Гомбо/, Булган сумын Засаг дарга /Д.Наранбаяр/ нарт үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



З.БАТЗОРИГ